

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2017.07.03

Өлгий.

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудитораас 2017 онд төрийн аудитын байгууллагын системийн хэмжээнд дэвшүүлсэн *“Төрийн аудитын тогтолцооны хууль эрх зүй, бодлогын шинэчлэл, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил болгох”* зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, төлөвлөсөн ажлуудаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллалаа.

Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан орлогчоор батлуулан, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг нь зохион байгуулж ажиллав.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд аудитын чиглэлээр 6 төрлийн 22, удирдлага зохион байгуулалтын талаар 10, хүний нөөцийн үйл ажиллагааны талаар 9, авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар 4, мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар 3, мэдээллийн техник, технологийн үйл ажиллагааны талаар 5, төсөв санхүү, аж ахуйн үйл ажиллагааны талаар 4, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 4, мэргэжлийн тасралтгүй сургалтын талаар 5 бүгд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Энэхүү зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 11 орон тоогоор ажиллаж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан зааварын дагуу Тэргүүлэх аудитор аудитын менежер, аудиторуудтай төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аймаг дахь төрийн аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/89 дүгээр тушаалаар тус Аудитын газрын орон тоог 11 байхаар баталсны дагуу тэргүүлэх аудитор, аудитын менежер 1, ахлах аудитор 3, аудитор 5, жолооч 1 гэсэн бүтэц, орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Тус аудитын газрын 2017 оны үйл ажиллагаанд нийт 255,1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилд 144,3 сая төгрөгийн төсвөөр ажиллаж, 144,3 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 144,2 сая төгрөгийг зарцуулав.

Эхний хагас жилд 125 ажлын өдөр буюу 11000 хүн/цаг ажиллахаас нийт 10648 хүн цаг ажиллав. Санхүүгийн тайлангийн аудитын үеэр ажлын ачааллаас шалтгаалан дунджаар 1196 хүн/цаг илүү ажилласан байна.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэл, нийцлийн аудит тус бүр 1-ийг, аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэлийн аудит 2-ыг, өөрсдийн санаачлагаар гүйцэтгэлийн аудит 2-ыг, 225 төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит тус тус хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүнгээр нийтдээ 23519,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн үүнээс 1793,0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 73,7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 750,1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага бичиж, биелэлтэд хяналт тавьж ажиллав. Нийт алдаа, зөрчлийн 95,2 хувийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлжээ.

Өмнөх оноос шилжин ирсэн 23,2 сая төгрөгийн төлбөрийн акт, 5,1 сая төгрөгийн албан шаардлага, 12 заалттай зөвлөмжийг бүртгэлд авч, хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллав.

Эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт 29,7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, актын биелэлт 30,7 хувьтай, 490,0 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангуулж, албан шаардлагын биелэлт 64,9 хувьтай тайлагнагдлаа. Төлбөрийн актаас 20,6 сая төгрөгийн, санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрөөс 31,6 сая төгрөгийн бүгд 52,2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Эхний хагаст хийсэн аудитын дүнгээр төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 13, бүртгэл тайлагналтай холбоотой 15, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 14, дотоод хяналтыг сайжруулах 11, бусад чиглэлээр 5, нийт 58 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 60,3 хувь нь биелэгдсэн дүн мэдээтэй тайлагнагдлаа.

Төсвийн тухай хууль, тогтоомж, стандартыг ханган ажиллаагүйгээс санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ихээхэн материаллаг дүнтэй алдаа, зөрчилтэй гаргаж Хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан, Дүгнэлт өгөхөөс татгалзсан хариу өгсөн, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан 29 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу хариуцлага тооцуулах саналыг холбогдох албан тушаалтануудад хүргүүлснээс 19 нь хэрэгжсэн хариу ирүүлээд байна.

Эхний хагас жилд өмнөх онуудад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн үр дүнгээр 3617,8 сая төгрөгийн, төлбөрийн акт, санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрийн дүнгээр 52,2 сая төгрөгийн, нийт 3670,0 сая төгрөгийн санхүүгийн, санхүүгийн бус 30 үр өгөөжийг бүртгэлд тусгаж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, тайлан мэдээнд тусгав.

Аймгийн аудитын газраас холбогдох хууль, журмын дагуу орон нутгийн өмчийн 1 аж ахуйн нэгж, 41 төсөвт байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийлгэхээр хараат бус аудитын 2 компани, 1 гэрээт аудитортой гэрээ байгуулж “Эрхийн бичиг” олгож, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам” болон санхүүгийн тайлангийн аудитын гарын авлагын бодлого, арга зүйг баримтлан шинэчлэгдсэн СТАУС-2.0 программыг 2016 оны санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглаж, амжилттай нэвтрүүлж ажиллаа.

ҮАГазраас нэвтрүүлсэн СТАУС-2,0 программын туршилт тохируулгын ажил удааширч, уг программыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ны үеэс аудитын ажилд нэвтрүүлж, ашиглаж эхэлсэн. Үүнээс шалтгаалж ҮАГ-аас тус аймагт хийхээр төлөвлөсөн СТАУС-2.0 программын танилцуулах сургалт хийгдээгүй бөгөөд аудиторуд уг программын үйл ажиллагааг өөрсдөө бие дааж судалж, сурах гэсээр хугацаа алдаж, 1 дүгээр сарын 25-наас аудитын ажилд ашиглаж эхэлсэн юм.

Энэ байдлаас болж санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатны ажлуудыг зэрэг хийж, программд оруулах шаардлага урган гарч аудиторудын ажлыг хүндрүүлсэнийг тэмдэглэж хэлэх хэрэгтэй байна.

Дээрхи хүндрэл бэрхшээл байсан ч бид төлөвлөгөөт ажлуудаа бүрэн хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлуудыг хэрэгжүүлж, СТАУС-2,0 программд оруулан баримтжуулж, хяналтыг хэрэгжүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 252 байгууллага, аж ахуйн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс 27 байгууллагын санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудиторов тушаалаар итгэл үзүүлж, 168 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 57 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд бие даасан дүгнэлт гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн нийт байгууллагын 81,4 хувийг буюу 183-ыг өөрийн аудиторуд, 18,6 хувийг буюу 42-ыг хувийн аудитын компанийн болон гэрээт аудиторуд хийж гүйцэтгэлээ. Санхүүгийн тайлангийн аудитад Аудитын газрын 9, хувийн аудитын 4, бүгд 13 аудитор ажиллаж, нийт 647 хүн/өдөр зарцуулан ажлын болон амралтын өдрүүдэд 1196 хүн/цаг илүү ажиллав.

2016 оны санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар:

- Зөрчилгүй санал дүгнэлт 47 байгууллага
- Хязгаарлалттай санал дүгнэлт 7 байгууллага
- Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 3 байгууллага нийт 57 байгууллагад дүгнэлт өгч ажилласан байна.

Энэ жилийн аудитаар төсвийн шууд захирагч 39, аж ахуйн нэгж 3, төвлөрүүлэн захирагч 14, төсвийн ерөнхийлөн захирагч 1, бүгд 57 нэгжийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, орон нутгийн харьяа 168 төсвийн шууд захирагч, сангуудын санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитын дүнгээр нийтдээ 22391,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 1793,0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 71,3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 40,8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 20483,8 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, арилгуулах талаар 37 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлээ.

Тайлант онд санхүүгийн аудитаар нийт 71.3 сая төгрөгийн 29 төлбөрийн акт тогтоож, өмнөх оны үлдэгдлийн хамт 28,3 сая төгрөгийн буюу 39,4 хувийг барагдууллаа.

Мөн санхүүгийн аудитаар 40.8 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлсний 9,3 сая төгрөгийн 6 албан шаардлага бүрэн хэрэгжсэн ба үлдэх хэсэг нь буюу 77,2 хувь нь хэрэгжих шатанд байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 28 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсний 19 нь хэрэгжсэн хариу ирүүлэв.

Аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 6, бүртгэл тайлагналтай холбоотой 15, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 10, дотоод хяналтыг сайжруулах 2, бусад 4 нийт 37 зөвлөмж өгснөөс 25 зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай хариу ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 67,5 хувьтай байна.

Санхүүгийн аудитаар нийтдээ 3670,0 сая төгрөгийн санхүүгийн, санхүүгийн бус 30 үр өгөөжийг бүртгэж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, мэдээ тайланд тусгалаа.

Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн нийтлэг алдаа зөрчлүүдийг дурьдвал:

- Санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тайлбар, тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй.
- Журналын бичилтийг буруу хийснээс санхүүгийн тайлан, тодруулга буруу илэрхийлэгдсэн.
- ХХОАТ, НДШ-ийн тооцоогоор үүссэн өр, авлагыг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй.
- Аудитын газраас өгсөн санхүүгийн тайлангийн СТАУС программын загвар Ексел маягыг буруу нөхөх, томъёотой мөрөнд тоо оруулах, засах зэргээр аудитын ажлыг хүндрүүлсэн.
- Засгийн газрын Е-тайлан цахим программд аудитлагдсан санхүүгийн тайланг алдаатай буруу шивж оруулсан, үүнийг сумын санхүүгийн алба, Санхүү төрийн сангийн хэлтсийн зүгээс хянаж баталгаажуулаагүйгээс аймгийн ТЕЗ-ийн СНТайлан зөрүүтэй нэгтгэгдсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаас илэрсэн нийтлэг алдаа зөрчлүүдийг дурьдвал:

- Санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тайлбар, тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн

ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй.

- Сумдын ОНХСангийн санхүүгийн тайланд 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангаас дутуу олгосон санхүүжилтийн авлага, 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсан.
- Засгийн газрын Е-тайлан цахим программд ОНХСангийн аудитлагдсан санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай буруу шивж оруулсан, Сум хөгжүүлэх сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлээгүй,
- Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Е-тайлан цахим программыг ашиглаж нэгтгээгүй, Санхүү төрийн сангийн хэлтсийн зүгээс хянаж баталгаажуулаагүйгээс аймгийн ТЕЗ-ийн СНТайлан зөрүүтэй нэгтгэгдсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын 2.4.1-д заасны дагуу Аймгийн аудитын газраас төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 2017 оны санхүүгийн тайланд хийх баталгаажуулах аудитын хуваарийн саналыг боловсруулж, итгэл үзүүлэн өнжөөх 37 байгууллага, түүвэрт хамрагдах байгууллага 70, бие даасан дүзгнэлт гаргах 132 нийт 240 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөж ЯАГ-ын Стратегийн удирдлагын газарт хугацаанд нь хүргүүлэв.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар.

Тус Аудитын газрын 2017 оны аудитын төлөвлөгөөнд 9 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсний 2 нь ЯАГ-ын нэгдсэн төлөвлөгөөт, 3 нь аймгийн ИТХ-ын захиалгат, 4 нь өөрсдийн санаачлагаар хийх аудит байна.

Эхний хагас жилд ЯАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 1, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, өөрсдийн санаачлагаар 2, бүгд 5 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, аудитад 40 байгууллага хамрагджээ. Гүйцэтгэлийн аудитад давхардсан тоогоор 6 хүн ажиллаж, 176 хүн/өдөр зарцуулжээ.

ЯАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, тайланг хугацаанд хүргүүллээ.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 622,4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 2,4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 209,2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 6 албан шаардлага өгсөний дээр 415,0 сая төгрөгийн зөрчил дутагдлыг засч залруулах, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын хяналтыг сайжруулах, бусад асуудалд чиглэгдсэн 9 заалт бүхий зөвлөмж өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн нийт 622,4 сая төгрөгийн 86 алдаа, зөрчлийг ангилж үзэхэд:

- Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 48 зөрчлийн 92,9 сая төгрөгийн,

- Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой 4 зөрчлийн 1,0 сая төгрөгийн
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 19 зөрчлийн 380,6 сая төгрөгийн,
- Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 1 зөрчлийн 24,9 сая төгрөгийн
- Худалдан авалттай холбоотой 1 зөрчлийн 19,3 сая төгрөгийн
- Бусад 13 зөрчлийн 103,7 сая төгрөгийн зөрчил бүртгэгдсэн байна.

Эхний хагас жилд гүйцэтгэлийн аудитын 5,1 сая төгрөгийн 1 албан шаардлага хэрэгжиж, биелэлтийн хувь 2,4 хувьтай гарав.

Гүйцэтгэлийн аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 3, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 4, дотоод хяналтыг сайжруулах 2, бүгд 9 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай хариу ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 11,1 хувьтай байна.

Гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт бага хувьтай гарч байгаа нь улирлын эцэст хийгдсэн аудитаар өгсөн хэрэгжих хугацаа болоогүй зөвлөмж, акт, албан шаардлага дараагийн улиралд шилжиж байгаатай холбоотой юм.

Аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар.

Тус Аудитын газрын 2017 оны аудитын төлөвлөгөөнд 5 нийцлийн аудит хийхээр төлөвлөсний 4 нь ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөт, 1 нь өөрсдийн санаачлагаар хийх аудит байна.

Эхний хагас жилд ҮАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 1, өөрсдийн санаачлагаар 1, бүгд 2 сэдвээр нийцлийн аудит хийж, аудитад 16 байгууллага хамрагдсан байна. Нийцлийн аудитад 3 хүн ажиллаж, 110 хүн/өдөр зарцуулав.

ҮАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтанд аудит хийж тайланг хугацаанд хүргүүллээ.

Нийцлийн аудитын дүнгээр нийтдээ 505.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 505.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын хяналтыг сайжруулах, бусад асуудалд чиглэгдсэн 3 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Нийцлийн аудитаар илэрсэн нийт 505,3 сая төгрөгийн 51 алдаа, зөрчлийг зөрчлийн нэр төрлөөр ангилж үзэхэд:

- Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 5 зөрчлийн 24.5 сая төгрөг
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 46 зөрчлийн 480.8 сая төгрөг байна.

Нийцлийн аудитаар 505.3 сая төгрөгийн 10 албан шаардлага өгсөнөөс 475,6 сая төгрөгийн 8 албан шаардлага буюу 94,1 хувь нь хэрэгжсэн.

Өмнөх оноос шилжиж ирсэн 9, тайлант онд 3, бүгд 12 зөвлөмж өгсөнөөс 9 зөвлөмж буюу 75,0 хувь нь хэрэгжсэн байна.

Өгсөн зөвлөмжийг ангилалаар нь авч үзвэл:

- Арвилан хэмнэх, үр нөлөөг сайжруулах талаар 4 зөвлөмж
- Дотоод хяналтыг сайжруулах талаар 7 зөвлөмж
- Бусад 1 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Тав. ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар.

Аймгийн ИТХ-ын захиалгаар 3 байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийхээс Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2016 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж дүнг баталгаажуулж, ИТХ-д хүргүүлсэн бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2016 оны үйл ажиллагаанд хийж байгаа аудит дуусаагүй байгаа болно.

Газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өөрсдийн санаачлагаар Өлгий сумын ЗДТГазар, Цагдаагийн газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтанд нийцлийн аудит хийж, дүнг баталгаажуулав.

Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны 2016 оны үйл ажиллагаанд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлан хянагдаж, байгууллагад санал авахаар хүргүүлсэн боловч тайлангийн төсөлд өгөх саналаа хугацаандаа ирүүлээгүйгээс дараагийн улиралд шилжүүлэв.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст 0,2 сая төгрөгийн зөрчилд 2 акт, Өлгий сумын ЗДТГазарт 1,4 сая төгрөгийн зөрчилд 1 акт, Цагдаагийн газарт 0,8 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоосон.

Мөн түүнчлэн төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, анхан шатны баримтын бүрдэлийг хангуулах, нягтлан бодох бүртгэл, тооцоо, дотоодын хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар Боловсрол, соёл, урлагийн газарт 57,6 сая төгрөгийн 2 албан шаардлага, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст 12,8 сая төгрөгийн 1 албан шаардлага, Өлгий сумын ЗДТГазарт 36,3 сая төгрөгийн 1 албан шаардлагаар тус тус үүрэг даалгавар өгөгдлөө.

Нийцлийн аудитын дүнгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах талаар 2 заалттай зөвлөмж хүргүүлэв.

Зургаа. Дотоод ажлын талаар.

6.1. Хүний нөөцийн ажлын талаар:

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны “Аймаг дахь төрийн аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл жиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/89 дүгээр тушаал гарсантай холбогдуулан Аймгийн аудитын газрын ажиллагсдын дэлгэрэнгүй судалгааг 2017 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар гаргаж ҮАГ-т хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны “Ажлаас чөлөөлж, мэдэлд авах тухай” Б/157 тоот тушаал гарсантай холбоотойгоор шинээр томилогдох ажилтнуудын ажлын байрны шаардлага хангаж байгаа эсэх талаарх судалгааг бэлтгэж, саналаа ҮАГ-ын сонгон шалгаруулалтын комисст хүргүүлэв.

Ахлах аудитор М.Хуанган тушаал дэвшиж дарга, тэргүүлэх аудитор болж, ахлах шинжээч С.Салтанат 5 дугаар сарын 01-нээс өндөр насны тэтгэвэр гарсан боловч шинэ бүтэц орон тоонд ажилтнуудыг томилсон Монгол Улсын Ерөнхий аудиторов тушаал гараагүй байгаа учир эхний хагас жилд ахлах аудиторов орон тоонд нөхөн томилгоо хийгдээгүй, хоёр аудиторт түр хариуцуулж ажиллуулав.

Ардын хувьсгалын 95 жилийн ойг тохиолдуулан аудитын менежер Х.Женисбекийг “Алтан гадас одон”-гоор, аудитор Х.Манаргүлийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар шагнуулахаар өнгөрсөн онд тодорхойлсон материалуудыг дахин бүрдүүлж, саналын хамт Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэв.

Ар гэрийн гачигдал гарсан аудитор К.Риза, Д.Назгүл, Х.Еркебулан нарт 5-8 хоногийн чөлөөг Тэргүүлэх аудиторов тушаалаар олгосон ба 3 хүртэлх өдрийн чөлөөг чөлөөний хуудсаар олгож байна.

6.2. Архив-албан хэрэг хөтлөлтийн талаар:

Тайлант хугацаанд ҮАГ-аар болон бусад байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг, и-мэйл нийт 233 албан бичгийг хүлээн авч бүртгэж, холбогдох ажилтнуудад шилжүүлэн, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллав.

Тайлант хугацаанд байгууллагаас гарсан нийт 173 албан бичгийг стандартын дагуу хэвлэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу хүргүүллээ.

Эхний хагас жилд аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов аудитын дүнг баталсан 6, хөрөнгө зарцуулахтай холбоотой 5, боловсон хүчинтэй холбоотой 6, бусад үйл ажиллагаатай холбоотой 4, нийт 21 тушаал гаргаж бүртгэлд авч, хэрэгжилтийг хангуулав.

Тайлант хугацаанд Удирдлагын зөвлөлийн хурлыг 7 удаа хуралдуулж санхүүгийн тайлангийн аудитын дүн болон гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудитын тайланг хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл хөтөлж албажуулав. Долоо хоногийн нэг дэх өдрийн өглөө бүр байгууллагын нийт ажилтнуудын өглөөний шурхай хурлыг хийж, хурлын тэмдэглэл 19-ыг хөтөлж баримтжуулав.

Акт, албан шаардлагын бланкын бүртгэлийг тус тусдаа хөтөлж, аудит хийсэн аудитор нарт шаардсан тоо хэмжээгээр хяналттай олгож, акт, албан шаардлагын 1 хувийг төрөл тус бүрээр нь хавтас нээн хадгалж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрыг өөрчлөн байгуулах тухай А/59 тоот тушаал гарсантай холбогдуулан байгууллагын тамга, тэмдэгийг шинээр хийлгэж, албан бичиг, акт, албан шаардлагын бланкны маягтуудыг шинэчлэв.

Аудитын газрын 2016 оны ажлын тайлан, мэдээ болон санхүүгийн тайлангийн аудитын тайлангийн баримт материалуудыг хариуцсан аудиторуудаар ХХНЖ-ийн дагуу нэгжилт хийлгэж, архивын нэгж үүсгэн 72 мемориал баримт болгон үдүүлж, байгууллагын архивт шилжүүлэв.

Оны эхэнд бүх ажилтнуудаас нууцын баталгааг зохих журмын дагуу гаргуулан авч, баримтжуулав. Аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг ажилтнуудаар гаргуулж, баталгаажуулж байгаа ба санхүүгийн тайлангийн аудитаар ёс зүйн батламжийг давхар гаргуулан авч баримтжууллаа.

6.3. Мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар:

YAГ-ын audit.mn вэб сайтад гүйцэтгэлийн аудит 4, нийцлийн аудит 2, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон бие даасан дүгнэлт гаргасан 51 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын тайлангуудыг байршуулсаны дээр аудитын чиглэлээр 16, цаг үеийн ажлын явцын талаар 7 мэдээ мэдээлэл тус тус бэлтгэж, байршуулан ажиллав.

Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой бусад мэдээллийг хуулийн хугацаанд нь shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсанд байршуулж мэдээлж байна. Мөн аймгийн ИТХурал, Засаг дарга нарт аудитын тайланг санал зөвлөмжийн хамт хэвлэн хүргүүлсний дээр хүсэлт гаргасан 7 байгууллагад аудитын 7 тайланг хувилж өгсөн байна.

Байгууллагын мэдээллийн самбарт аудитын дүнгийн талаар, цаг үеийн ажлын талаар товч мэдээлэл бэлтгэж байршуулав. Орон нутгийн “Дербес” хувийн телевизээр санхүүгийн тайлангийн аудитын явцын талаар 1 удаа мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэв.

6.4. Сургалт, семинар, зөвлөгөөний талаар:

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт, семинар, зөвлөгөөнд 5 дугаар сарын 16-20-ний өдрүүдэд дарга, тэргүүлэх аудитор, аудитор менежер нар оролцов.

Аймгийн ЗДТГ-аас Хууль зүйн яамтай хамтран 5 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан Захиргааны ерөнхий хуулийн талаарх сургалтад тэргүүлэх аудитор, аудитын менежер нар хамрагдав.

YAГазраас зохион байгуулсан онлайн хурал, сургалтуудад тухай бүр тэргүүлэх аудитор, аудитын менежер болон аудиторуудыг оролцуулж байна.

ММНБИ-ээс тасралтгүй сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан “мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах” сургалтад аудитор Д.Назгүл 3 дугаар

сарын 27-ноос 4 дүгээр сарын 5-ны хооронд хамрагдаж, шалгалт өгч хугацаагүй эрхтэй ММНБ-ийн гэрчилгээгээ авсан.

6.5. Мэдээллийн технологийн чиглэлээр

Дотоод сүлжээний сервер тоног төхөөрөмжийг хэвийн ажиллуулан, саатал гарсан тухай бүрд нь ҮАГ-ын мэдээлэл технологийн мэргэжилтнүүдтэй холбогдон засварлаж, сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажиллаа.

Ажлын компьютер, техник хэрэгсэлийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах үүднээс “Касперский 2017” албан ёсны зөвшөөрөлтэй антивирусны программыг 1 дүгээр сард бүх компьютерт суулган, хамгаалалттай болгож ашиглаж байна.

ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2017 оны 4 дүгээр сарас эхлэн газрын долоо хоногийн ажлын тайланг тав дахь өдөр бүр ҮАГ-ын цахим оффист тогтмол байршуулж мэдээлж байна.

6.6. Бусад ажлын талаар:

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр Аймгийн Засаг даргын тамгын газраас 2017 оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан мод тарих өдөрлөгт бүх ажилтнуудыг хамруулж, Өлгий-Улаанбаатар чиглэлийн зам дагуу байрлах мод үржүүлгийн газарт 20 ширхэг шар хуайсны суулгац тарьж Сум дундын ойн ангид хүлээлгэн өгөв.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/70 тоот захирамжаар эмзэг бүлгийн өрхийн судалгааг гарган, амьжиргааны түвшин доогуур өрхүүдийг орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хуваарилан тусламж дэмжлэг үзүүлэх санаачлага, ирүүлсэн албан бичгийн дагуу Өлгий сумын 4 дүгээр багийн өрх толгойлсон эх М.Алмагийн гэр бүлд нийт ажилтнууд хувиасаа хандив цуглуулж 100,0 мянган төгрөгийн туламж үзүүлэв.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Тайлангийн хугацаанд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт байгууллага, иргэдээс ирүүлсэн 16 өргөдөл гомдол, хүсэлтийг бүртгэлд авч, холбогдох ажилтнуудад шилжүүлэн, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллав. 3 өргөдлийг ирүүлсэн байгууллага, иргэд өөрсдөө буцааж авсан болно.

Байгууллагын ажилчдаас 4, төрийн аудитын байгууллагад ажилд орохыг хүссэн 2, цалингийн зэрэглэл, нэмэгдэлтэй холбоотой 6, бусад асуудлаар 1 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс 12 өргөдөлийг шийдвэрлэж хариу өгч, 1 өргөдөл шалгагдаж байна.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар.

7.1. Санхүүгийн тайлангийн талаар

Байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд гаргаж, ҮАГ-ын хууваарийн дагуу “Улаанбаатар Аудит корпораци” ХХК-д хүргүүлж аудит хийлгэв. Аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч, 760,0 мянган

төгрөгийн зөрчил илэрч, 2 заалттай зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж, дүнг хугацаанд тайлагнасан болно.

Тус газрын 2017 эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар нийт 26,2 сая төгрөгийн хөрөнгөтэй ба 11,8 хувь буюу 3,1 сая төгрөг нь эргэлтийн хөрөнгө, 88,2 хувь буюу 23,1 сая төгрөг нь үндсэн хөрөнгө байна.

Тайлангийн хугацааны эцэст 202,8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, бараа материалын үлдэгдэл оны эхнээс 858,0 мянган төгрөгөөр нэмэгдэж 3856,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Оны эхэнд үндсэн хөрөнгө анхны өртгөөр 111317,0 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд орлого ороогүй бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийг авч 13144,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж данснаас хассан. Үндсэн хөрөнгөнд 7489,1 мянган төгрөгийн элэгдэл тооцож, тайлант хугацааны эцэст 23078,8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

Оны эхэнд 2492,4 мянган төгрөгийн авлага, 702,0 мянган төгрөгийн өглөгтэй байсныг бүрэн барагдуулж, хагас жилээр өр, авлагагүй гарав.

Аудитын газрын 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны 17 дугаар тушаалаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” хөрөнгийн тооллого явуулж, Өмч хамгаалах комисс актлах хөрөнгийн жагсаалтыг бэлтгэж саналаа ҮАГ-т хүргүүлэв.

7.2.Төсвийн гүйцэтгэлийн талаар.

Тус аудитын газрын 2017 оны үйл ажиллагаанд 255,1 сая төгрөгийн төсөв батлагдснаас эхний хагас жилд 144,3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаа. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 144,3 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулан батлагдсан төсвөөс 88,7 мянган төгрөгөөр бага зардал гаргав.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл үндсэн цалинд 89824,3 мянган төгрөгийг, унаа хоолны хөнгөлөлтөнд 2032,8 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 10104,6 мянган төгрөгийг, хангамж, бараа материалын зардалд 3948,6 мянган төгрөгийг, албан томилолтонд 3342,0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 4184,8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Цалингийн зардал 2,8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалын зардал 85,8 мянган төгрөгөөр хэмнэгдлээ. Хэтэрсэн зардал байхгүй болно.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайлан, НДШ, ХХОАТатварын тайланг заавар журмын дагуу гаргаж холбогдох газруудад хугацаанд хүргүүлж ажилласан.

Аудитын газрын 2018 оны урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, 2018-2020 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж ҮАГ-т хүргүүлсэн.

Найм. Дүгнэлт, санал

Үндэсний аудитын газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газар нь 2017 оны эхний хасаг жилд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

СТАУС-2.0 программын туршилт тохируулгын ажил хугацаа алдаж хийгдсэн нь санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн ажлыг зэрэг хийхэд хүргэж, үндрэл учрууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН:**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР****М.ХУАНГАН**